

ДЭЛХИЙН СОЁЛЫН БИЕТ ӨВД БҮРТГЭГДСЭН НОМ СУДАР

1



D.Urantsetseg@must.edu.mn

ДЭЛХИЙН СОЁЛЫН БИЕТ ӨВД БҮРТГЭГДСЭН МОНГОЛ НОМ СУДРЫГ МЭДЭХ

- XIX зууны сүүлээр Богд хан уулын өмнө орших Манзуширийн хийдэд Дагва тэргүүтэй дархчууд сүсэгтэн олны хандиваар бүтээжээ. Уг хийдэд Манзушири хутагт Цэрэндорж эзэмшиж байсныг хожим Богд хааны номын сангаар дамжуулан 1924 онд Үндэсний номын санд шилжүүлжээ.
- Мөнгөн хуудсыг хөөмөлдөн алтдаж, найман мөрөөр бичсэн, нийт 1460 лан буюу 52 кг 560 гр алт, мөнгө орсон. Хуудас бүрийг суман модон хавтсанд суулгаж, судрын 50 орчим хуудсанд бурхадын дүрийг товойлгон бүтээсэн бөгөөд ханд дагинисыг хатгаж урласан торгон хөшигтэй.
- Монгол Улсын Засгийн Газрын 1995 оны 241-р тогтоолоор түүх соёлын “ХОСГҮЙ ҮНЭТ” өвд бүртгэжээ.

САНДУЙН ЖУД



ЖАДАМБА СУДАР



"Эртний хаадын үндэслэсэн төрт ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч оршвой"

- Лу.Алтан товчийг ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрт 2011 онд бүртгэсэн.
- XVII зууны үед амьдарч байсан монголын эрдэмтэн гүүш Лувсанданзан Чингис хаанаас Лигдэн хаан хүртэлх үеийг хамран өгүүлсэн "Эртний хаадын үндэслэсэн төрт ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч оршвой" хэмээх шастирыг туурвин зохиожээ. 1651 онд зохиогдсон
- Лу.Алтан товчид Монголын нууц товчооны 282 зүйлээс 233 зүйл нь хэвээрээ байхаас гадна Монголын нууц товчоонд байхгүй олон нэмэлт бүлэг байдаг

ЛУВСАНДАНЗАН “АЛТАН ТОВЧ”



Ганжуур-бурхан багшийн
амаараа айлдсан сургаал
юм. Ганжуур нь монгол
хэл дээр 113 боть байдаг.

Данжуур нь 226 боть
судар юм. Данжуурыг
1742-1749 онд Бээжинд
226 ботиор барлажээ.



НОГООН ДАРЬ ЭХИЙН МАГТААЛ

Сангажавын Шагж 1914 онд 55 мм шоо дөрвөлжин хэмжээтэй цаасан дээр хялгасан бийрээр бичсэн байдаг. Төвд үсгээр бичсэн энэ бүтээл одоогоор Монгол улсын хамгийн жижиг номонд тооцогддог юм. “Сахиусан дарь эх” гэж нэрлэгддэг энэ ном өнөөдөр манай улсын төв номын сангийн үнэт ховор номын музейд хадгалагдаж байна. Шагж гуай энэ номоо зуны аагим нартай өдөр гэрийнхээ өрхийг битүүлэн татаж, өрхний завсраар туссан нарны өчүүхэн гэрэлд бичсэн гэдэг.

НОГООН ДАРЬ ЭХ



МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО

Монголын соёлын анханд тооцогдох түүхийн болон уран зохиолын бичгийн дурсгал юм. Нууц товчооны монгол бичгээр бичсэн эх олдоогүй бөгөөд ханз үсгээр монгол хэлийг тэмдэглэж, хятад орчуулгыг хадсан Мин улсын үеийн эх бичиг нь эдүгээгийн нууц товчооны үндэс болсон. Нууц товчоог Бодлогот Баатар Цэнд Гүн анх Монгол бичгээр сийрүүлэн орчуулж, Ц.Дамдинсүрэн орчин цагийн монгол хэлнээ буулгасан. Япон, англи зэрэг 30 гаруй гадаад хэлээр 1000 орчим хувилбараар хэвлээд байна. 1990 онд Нууц товчооны 750 жилийн ойг төрийн хэмжээнд тэмдэглэсэн.

ТӨРИЙН ОРДОНД ЗАЛСАН "МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО" 11



ЭХ СУРВАЛЖ

https://www.facebook.com/watch/live/?v=1045869102534488&ref=watch_permalink

